



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № 01/772
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ХАЙЧААГИЙН БАТБАЯР ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Хайчаагийн Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Хайчаагийн Батбаярын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Хайчаагийн Батбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Хайчаагийн Батбаярт.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд.

Хавсралт /... хуудастай.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ХАЙЧААГИЙН БАТБАЯРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

1. Мэдлэг, ур чадвар, мэргэшилд нь тохирсон цалин хөлс, эдийн засгийн баталгаагаар хангах замаар авилга, хээл хахуулаас ангид, үнэнч шударга, ёс суртахуунтай хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэхийг уриалж ажиллана.
2. Сонгуулийн амлалтаа биелүүлээгүй нам, улс төрчдөд ёс суртахууны хариуцлага хүлээдэг тогтолцоог бий болгоход манлайлан ажиллана.
3. Төсөв, мөнгө, боловсон хүчний болон эд хөрөнгөний эрх мэдлийг бодитой шилжүүлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангаж ажиллана.
4. Ядуурал, ажилгүйдлийг арилгаж, чинээлэг дундаж давхаргыг бүрдүүлэх талаар, иргэдийнхээ амьдралын түвшин ба чанарт томоохон өөрчлөлт хийхийг зорино.
5. Өрхийн тэргүүн бүрийг ажлын байртай, байнгын орлоготой болгох замаар ядуурлыг бууруулах цогц арга хэмжээ авна.
6. Улс орны хөгжил дэвшлийн хөдөлгөгч хүч болсон залуучуудынхаа сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, ая тухтай амьдрах боломж нөхцөлийг сайжруулах бодлого явуулна.
7. Ажлын байр нэмэгдүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгосон аж ахуй нэгж, ажлын байрандаа олон жил тогтвор суурьшилтай ажилласан иргэдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр санаачилна.
8. Орон нутагт шилжин суурьшиж байгаа залуучуудыг ажлын байраар хангах, бизнес эрхлэх сонирхолтой хүмүүсийг хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах, төрийн байгууллага, тэр дундаа эрүүл мэнд, боловсролын байгууллага болон төрийн захиргааны байгууллагад шилжин ирж ажиллаж байгаа албан хаагчдын орон байрны асуудалд анхаарал хандуулан ажиллана.
9. Ахмад настан, эх нялхаст зориулсан сэргээн засах эмчилгээ, сувилгааны цогцолбор бий болгоход санаачлагатай манлайлан ажиллана.
10. Аймгийн дулааны станцыг өргөтгөн шинэчлэх талаар идэвхи санаачлагатай ажиллана.
11. Аймгийн төв, сумын төвүүдэд орон сууц хөтөлбөрийг боловсруулан ажиллана.
12. Агаарын бохирдолыг бууруулах тэрбум мод хөтөлбөр ногоон хөгжлийг дэмжин ажиллана.



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

Х.БАТБАЯР

0000000001